



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.04.18 № 188  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
ГҮЙЦЭТГЭЛ НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ГАЗАРТ**

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын  
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын  
тайланг хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Т.ПҮРЭВЛХАГВА



## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлыг тооцоолоогүй төсөл арга хэмжээг төлөвлөж, хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалт хангалтгүйгээс үр дүнг тооцох боломжгүй байна.

АУДИТЫН КОД: ОРА-2025/06-13-ШТА-ГА



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: [purevlkhagvar@audit.gov.mn](mailto:purevlkhagvar@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: [buyanundrakhb@audit.gov.mn](mailto:buyanundrakhb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Т.Болормаа

Утас: 70355805 Цахим хаяг: [bolormaat@audit.gov.mn](mailto:bolormaat@audit.gov.mn)

Аудитор: Ц.Одгэрэл

Утас: 70357955 Цахим хаяг: [odgerelts@audit.gov.mn](mailto:odgerelts@audit.gov.mn)

Аудитор: А.Лхагвагэрэл

Утас: 70355805 Цахим хаяг: [lkhagvaqerela@audit.gov.mn](mailto:lkhagvaqerela@audit.gov.mn)

Товчилсон үгийн жагсаалт.....	3
Хүснэгтийн товъёг.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдээлэл.....	4
Үндсэн мэдээлэл .....	6
БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээний 23 хувийг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлыг тооцоолоогүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна. ....	8
БҮЛЭГ 2. Төлөвлөсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан боловч техникийн тодорхойлолтыг бодитой хийгээгүйгээс зах зээлийн үнээс хэт өндөр дүнтэй тоног төхөөрөмж худалдаж авчээ. ....	13
БҮЛЭГ 3. Төсөл арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлж байгаа ч хөрөнгийн хэрэгцээ шаардлага оновчгүйгээс ашиглалт хангалтгүй, хяналтгүй байна. ....	17
Дүгнэлт:.....	31
Зөвлөмж:.....	32
Байгууллагын санал:.....	33

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУ	Монгол улс
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ЗГХЭГД	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга
ЗТХС	Зам тээвэр хөгжлийн сайд
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ЭЗХС	Эдийн засаг, хөгжлийн сайд
ХББОСС	Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд
БС	Боловсролын сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ЭШХО	Эрх шилжсэн хөрөнгө оруулалт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ШУТП	Шинжлэх ухаан технологийн парк

**Хүснэгтийн товьёг**

Хүснэгт 1	Орхон аймагт хэрэгжих ТАХ тоо
Хүснэгт 2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан ТАХ
Хүснэгт 3	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ТАХ
Хүснэгт 4	Дэд бүтэцтэй холбоотой ТАХ
Хүснэгт 5	Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй нийцээгүй ТАХ
Хүснэгт 6	Эдийн засгийн үр ашиг тодорхойгүй ТАХ
Хүснэгт 7	Орон нутагт бүртгэлтэй боловч хувийн хэвшилд ашиглах ТАХ
Хүснэгт 8	Эрх шилжсэн ТАХ-ний жагсаалт
Хүснэгт 9	ХАА зохион байгуулсан байдал
Хүснэгт 10	Зах зээлийн үнээс өндөр үнэтэй тоног, төхөөрөмж
Хүснэгт 11	Зах зээлийн үнээс өндөр үнэтэй тоног, төхөөрөмж
Хүснэгт 12	Санхүүжилтийн мэдээлэл
Хүснэгт 13	ТАХ хүлээлгэн өгсөн жагсаалт

Хүснэгт 14

Бусад байгууллагад хүлээлгэн өгсөн жагсаалт

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдээлэл****Аудит хийх  
үндэслэл, бүрэн  
эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөөний ” дагуу аудитыг хийж гүйцэтгэв.

**Аудитын зорилт**

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх,
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

**Аудитын хамарсан  
хүрээ**

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, аймгийн Засаг даргын тамгын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, Хот байгуулалт барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ зэрэг холбогдох байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан гүйцэтгэлээ.

**Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

**Аудитын шалгуур үзүүлэлт**

Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр,
- Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах хэрэгжүүлэн, ахлах аудитор Т.Болормаа, аудитор Ц.Одгэрэл, А.Лхагвагэрэл нар 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

**Аудитын явцад  
учирсан хүндрэл,  
бэрхшээлүүд**

Аудитын явцад хүндрэл, бэрхшээл үүсээгүй болно.

## Үндсэн мэдээлэл

Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад Орхон аймагт 131,950.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30 төсөл арга хэмжээг 45,121.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

## Орхон аймагт хэрэгжих ТАХ тоо

Хүснэгт 1

/сая төгрөгөөр/

№	Сайдын багц	ТАХ-ний тоо	Эрх шилжсэн ТАХ-ний тоо	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Хуулиар батлагдсан санхүүжих дүн	ТЕЗ өөрчлөлт оруулсан санхүүжих дүн	Гүйцэтгэлээрх санхүүжилт	Үлдэгдэл санхүүжилт
1	ЭЗХС	2	2	-	3,241.2	3,241.2	3,241.2	3,095.4	145.8
2	Шадар сайд	2	0	-	558.0	558.0	558.0	499.5	58.5
3	ЗГХЭГД	1	1	2,050.0	2,789.3	199.3	199.3	199.0	0.3
4	БС	11	3	22,856.8	82,758.2	27,791.3	27,791.3	16,010.9	11,780.3
5	ХББОСС	7	0	34,992.5	34,162.2	6,726.0	6,726.0	258.7	0.0
6	ХХААХҮС	5	5	-	4,520.0	4,520.0	4,520.0	4,322.2	197.8
7	ЭМС	1	0	-	3,671.8	1,835.9	1,835.9	-	1,835.9
8	ССАЖЗС	1	1	-	250.0	250.0	250.0	238.5	11.5
	<b>Нийт</b>	<b>30</b>	<b>12</b>	<b>59,899.3</b>	<b>131,950.7</b>	<b>45,121.7</b>	<b>45,121.7</b>	<b>24,624.2</b>	<b>14,030.1</b>

Орхон аймагт хэрэгжихээр төлөвлөсөн 30 төсөл арга хэмжээнээс Засаг даргад эрх шилжсэн 12, тайлант онд шинээр эхэлж буй 15, өмнөх оноос он дамжин хэрэгжиж буй 15 төсөл арга хэмжээ байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын Орхон аймагт хэрэгжих 30 төсөл арга хэмжээнээс 9 төсөл арга хэмжээ нь тоног төхөөрөмж, 21 барилга байгууламжийн төсөл арга хэмжээ төлөвлөжээ.

Тайлант онд хэрэгжих 30 төсөл арга хэмжээнээс 26,452.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 9,519.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 15 төсөл арга хэмжээ бүрэн дууссан байна.

## Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан ТАХ

Хүснэгт 2

/сая төгрөгөөр/

№	Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	2024 оны төсөвт өртөг	Гүйцэтгэлээрх Санхүүжилт
1	III.2.3.1	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	783.0	646.3
2	IV.1.3.5	Онцгой байдлын тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	180.0	172.2

3	IV.3.3.1	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	378.0	327.3
4	V.1.4	Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/	2,789.3	199.0
5	XIII.1.1.201	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг/	7,406.3	3,186.5
6	XIII.1.1.1	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/	1,626.6	20.7
7	XVI.2.3.13	Орхон аймгийн Номын сангийн тоног төхөөрөмж	250.0	250.0
8	XVII.1.9	Багийн явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэнбүст баг/	2,173.4	258.7
9	XVIII.3.27	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/	820.0	720.9
10	XVIII.3.6	"Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	441.4
11	XVIII.3.7	"Шинэ хөдөө-хүлэмж" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	492.5
12	XVIII.3.8	"Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	467.4
13	XVIII.3.9	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	2,200.0	2,200.0
14	XVII.1.30.2	Төв дулааны цэвэр усны шугам, ус дулаан дамжуулах төвийн барилга, гадна инженерийн шугам сүлжээний ажил /Орхон, Баян-Өндөр сум, Их залуу баг/	1,369.0	136.9
15	XII.3.1.2	Хот хоорондын болон аймаг хоорондын зорчигч тээврийн авто буудал /Орхон, Баян-Өндөр сум/	4,976.7	-
<b>Нийт дүн</b>			<b>26,452.3</b>	<b>9,519.8</b>

Тайлант онд батлагдсан төсөл арга хэмжээнээс огт эхлээгүй 5 ТАХ байна. Үүнд:

- Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2А хороолол/
- Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2а хороолол/
- "Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төсөл"-ийн хүрээнд хэрэгжүүлсэн 20,000 м3/хоног хүчин чадал бүхий биологи цэвэрлэгээний цэвэрлэх байгууламжийн нэмэлт ажил.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум/

**БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээний 23 хувийг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлыг тооцоолоогүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.**

1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Улсын хөгжлийн жилийн 2024 оны төлөвлөгөөтэй 80 хувь уялдаж байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.3<sup>1</sup>-т заасны дагуу УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг баталжээ.

Тус хөгжлийн төлөвлөгөөний 3.1<sup>2</sup>-т заасан зорилгын хүрээнд 2 сайдын багцад 83,008.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28,041.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 12 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн нь Орхон аймагт улсын төсвөөс хэрэгжих нийт хөрөнгө оруулалтын 40 хувийг эзэлж байна.

**Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ**

Хүснэгт 3

/сая төгрөгөөр/

№	Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	2024 оны төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	XIII.1.1.1	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/	1,626.6	20.7
2	XIII.1.1.181	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/	16,489.3	4,190.8
3	XIII.1.1.201	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг/	7,406.3	3,186.5
4	XIII.1.1.309	Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/	15,795.2	4,738.6
5	XIII.1.1.310	Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2А хороолол/	15,795.2	4,738.6
6	XIII.1.1.330	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/	2,916.3	1,458.2
7	XIII.1.1.362	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2а хороолол/	3,473.8	1,800.0
8	XIII.1.1.4	Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/	800.0	279.3
9	XIII.1.1.6	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/	3,953.6	100.0
10	XIII.1.1.68	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/	3,944.2	45.0
11	XIII.2.1.1	Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/	10,557.7	7,233.6
12	XVI.2.3.13	Орхон аймгийн Номын сангийн тоног төхөөрөмж	250.0	250.0
<b>Нийт дүн</b>			<b>83,008.2</b>	<b>28,041.3</b>

<sup>1</sup> улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх

<sup>2</sup> Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг баталсан.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.5.12<sup>3</sup>-т заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 34,992.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 6,726.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн нь нийт хөрөнгө оруулалтын 23.3%-ийг эзэлж байна.

### Дэд бүтэцтэй холбоотой төсөл, арга хэмжээ

Хүснэгт 4

/сая төгрөгөөр/

№	Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	2024 оны төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	XVII.1.30.1	Ф720 мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөлийн ажил /Орхон, Баян-Өндөр сум/	4,321.2	1,682.7
2	XVII.1.30.2	Төв дулааны цэвэр усны шугам, ус дулаан дамжуулах төвийн барилга, гадна инженерийн шугам сүлжээний ажил /Орхон, Баян-Өндөр сум, Их залуу баг/	1,369.0	136.9
3	XVII.1.30.23	"Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төсөл"-ийн хүрээнд хэрэгжүүлсэн 20000 м3/хоног хүчин чадал бүхий биологи цэвэрлэгээний цэвэрлэх байгууламжийн нэмэлт ажил /Орхон/ Шүүхийн шийдвэртэй	1,003.7	-
4	XVII.1.30.3	Төв дулаан, цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ус дулаан дамжуулах төв барих ажил /Орхон, Баян-Өндөр сум, Цагаан чулуут, Наран баг/	4,330.0	1,149.5
5	XVII.1.30.4	Эрх чөлөөний гудамжны уулзварын өргөтгөлийн инженер шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /Орхон, Баян-Өндөр сум, Уурхайчин баг/	1,992.2	1,298.2
6	XVII.1.30.5	Ариутгах татуургын 3-р коллекторын төв шугам татах ажил /Орхон, Баян-Өндөр сум/	19,976.4	2,200.0
7	XVII.1.9	Багийн явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэн бүст баг/	2,000.0	258.7
<b>Нийт</b>			<b>34,992.5</b>	<b>6,726.0</b>

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.4<sup>4</sup>-т заасны дагуу 3,347.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 757.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл арга хэмжээ, 2.2.4<sup>5</sup> гэсэн заалтын дагуу 3,671.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,835.9 сая төгрөгийн

<sup>3</sup>Төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглээгийг хэсэгчилсэн бие даасан инженерийн хангамжид холбох, бичил дэд төвүүдийг байгуулах төслийг үе шаттай хэрэгжүүлнэ.

<sup>4</sup>Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд үзүүлэх төрийн үйлчилгээг тодорхойлж, шат дамжлагыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

<sup>5</sup>Аймаг, дүүргийн түвшинд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулна

санхүүжих дүнтэй 1 төсөл арга хэмжээ нийт 4 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн нь Орхон аймагт хэрэгжих улсын төсвийн хөрөнгө оруулалтын 13.3%-ийг эзэлж байна.

Харин Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тодорхой тусгагдаагүй 5,303.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 5,303.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл арга хэмжээ тусгагдсан нь нийт хөрөнгө оруулалтын 20%-ийг эзэлж байна.

### МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй нийцээгүй ТАХ

Хүснэгт 5

/сая төгрөгөөр/

№	Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	2024 оны төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	XVIII.3.27	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/	820.0	820.0
2	XVIII.3.6	"Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	500.0
3	XVIII.3.7	"Шинэ хөдөө-хүлэмж" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	500.0
4	XVIII.3.8	"Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	500.0
5	XVIII.3.9	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	2,200.0	2,200.0
6	III.2.3.1	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	783.0	783.0
<b>Нийт</b>			<b>5,303.0</b>	<b>5,303.0</b>

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Орхон аймагт хэрэгжихээр төлөвлөсөн 30 төсөл арга хэмжээний 80% нь Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нийцэж байна.

### 1.2 Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй 7,761.2 сая төгрөгийн 7 ТАХ байна.

МУ-ын Шадар сайд, БС, ЗГХЭГД-ын багцад батлагдсан 23,008.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ нь нийгмийн ач холбогдолтой ТАХ-г төлөвлөжээ. Тухайлбал:

- 8-р сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал ТАХ нь 1500 суралцагч тав тухтай орчин нөхцөл, шинэ спорт зааланд хичээллэх боломжоор хангагдаж, ахлах суралцагч нар 3 ээлжээр хичээллэж байсныг болиулж, ахлах ангийн суралцагч нар өглөө орж, сонгон хичээлдээ хамрагдах боломж олгогдсон байна.
- Орхон аймгийн Номын сангийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр оюутан суралцагч нар хичээлээ чөлөөтэй судлах, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, МУ-дах АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран Америк төв Эрдэнэтээр дамжуулан үнэ төлбөргүй сургалтуудыг авах боломж бүрдсэн байна.
- Стандарт, хэмжил зүйн хэлтсийн тоног төхөөрөмжтэй болсноор 2024 оны байдлаар нян судлалын лаборатори нь 2,027 дээжид 4,677 үзүүлэлтээр, химийн хор судлалын лаборатори нь 1,963 дээжид 7,661 үзүүлэлтээр, таримал, ургамал

үр хорио цээрийн лаборатори нь 468 дээжид 885 үзүүлэлтээр, нийт 4,458 дээжид 13,223 үзүүлэлтээр шинжилгээ хийх хүчин чадалтай болсон байна.

Харин ХХААХҮС-ийн багцаас аймгийн Засаг даргад эрх шилжсэн 4,520.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ, ЭЗХС-ийн багцаас 3,241.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ нь орон нутагт нэн шаардлагатай өрхийн болон бичил бизнесийг дэмжихэд ач холбогдолтой ТАХ боловч, захиалагч эдийн засгийн үр ашгийн тодорхой тооцоолоогүй, нийгмийн ач холбогдлыг оновчтой тодорхойлоогүйгээс үр дүнг бууруулжээ.

### Эдийн засгийн үр ашиг тодорхойгүй төсөл арга хэмжээ

Хүснэгт 6

/сая төгрөгөөр/

№	Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	2024 оны төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	XVIII.3.27	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/	820.0	820.0
2	XVIII.3.6	"Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	500.0
3	XVIII.3.7	"Шинэ хөдөө-хүлэмж" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	500.0
4	XVIII.3.8	"Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	500.0
5	XVIII.3.9	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	2,200.0	2,200.0
6	III.2.1.3	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн барилга /Орхон, Баян-Өндөр сум	2,458.2	2,458.2
7	III.2.3.1	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	783.0	783.0
<b>Нийт</b>			<b>7,761.2</b>	<b>7,761.2</b>

ХХААХҮС-ийн багцын 5 ТАХ-ээр 4,322.2 сая төгрөгийн 2,301 ширхэг тоног төхөөрөмж, бусад эд хогшил нийлүүлэгдсэн боловч Хүнс хөдөө аж ахуйн газар, Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-аар дамжин иргэдэд ашиглуулж буй нь үр дүнтэй ТАХ эсэхийг нотлох боломжгүй байна.

ЭЗХС-ын багцын Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн барилгын ажлын гүйцэтгэл 90%-тэй, ашиглалтад оруулсны дараагаар бордооны үйлдвэр хийхээр төлөвлөсөн боловч хамтран ажиллах байгууллага тодорхойгүй, үйлдвэрийн тоног төхөөрөмж бэлэн бус, ашиглалтын зардлыг хэрхэн төлөх талаар тооцоо судалгаагүй ТАХ төлөвлөжээ.

Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмжийг 7 багц болгосноос 217.2 сая төгрөгийн 4 төрлийн тээврийн хэрэгсэл нийлүүлэгдэж, ашиглалтгүй байсныг аймгийн Засаг даргын захирамжаар төрийн 3 байгууллагад шилжүүлсэн нь хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй ТАХ төлөвлөсөн байна гэж үзлээ.

1.3 Орхон аймгийн 8-р сургуулийн өргөтгөлийн урсгал зардлыг тооцоолоогүйгээс 13.0 сая төгрөгийн өр төлбөр ашиглагч байгууллагад үүссэн байна.

Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс /*primis.publicinvestment.gov.mn*/ цахим системд 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгуулах 70 барилга байгууламж, 3 их засвар, 39 тоног төхөөрөмж, 2 ТЭЗҮ нийт 114 төсөл арга хэмжээний саналыг шалгуур үзүүлэлтийн дагуу оруулсан байна.

Цахим системд оруулсан саналаас 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 21 барилга байгууламж, 9 тоног төхөөрөмжийн төсөл арга хэмжээ батлагджээ. 2024 оны 12 дугаар сард ашиглалтад орсон Орхон аймгийн Баян-Өндөр сумын Оюут багийн сургуулийн өргөтгөлийн барилгын тогтмол зардлыг тооцоолоогүйгээс 13.0 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Мөн 2025 оны 08 сард ашиглалтад орох төлөвлөгөөтэй мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, Баян-Өндөр сумын 3 дугаар сургуулийн хичээлийн байр, спорт заалны урсгал зардлын тооцоог 2025 оны төсөвт нэмж батлаагүй нь өр төлбөр үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Шинжлэх ухаан технологийн паркийн 2,458.2 сая төгрөгийн өртөгтэй барилгын урсгал зардлын тооцоо, судалгааг хийлгүй 2025 оны 05 дугаар сард гүйцэтгэгчээс ашиглагчид хүлээлгэн өгөх төлөвтэй байна. Энэ нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 1,185.1 сая төгрөгийн алдагдалтай, өөрийн орлогоор зардлаа бүрэн санхүүжүүлэх чадваргүй “Шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ-т санхүүгийн ачаалал үүсгэх төсөл арга хэмжээ төлөвлөсөн байна.

#### 1.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн ТАХ-д хувийн өмчид шилжих, ашиг олох зорилготой 4,309.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээ төлөвлөсөн байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн 13.3.2<sup>6</sup>-т заасныг зөрчсөн 5,303.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээ төлөвлөгджээ.Үүнд:

#### Орон нутагт бүртгэлтэй боловч хувийн хэвшилд ашиглах ТАХ

Хүснэгт 7

/сая төгрөгөөр/

№	Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	2024 оны төсөвт өртөг	Гүйцэтгэлээрх санхүүжилт
1	XVIII.3.27	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/	820.0	720.9
2	XVIII.3.6	"Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	441.4
3	XVIII.3.7	"Шинэ хөдөө-хүлэмж" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	492.5
4	XVIII.3.8	"Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	467.4
5	XVIII.3.9	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	2,200.0	2,200.0
6	III.2.3.1	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	783.0	646.3

<sup>6</sup>“ хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ

Нийт

5,303.0

4,968.5

ХХААХҮС, Эдийн засгийн хөгжлийн сайдын багцаас эрх шилжсэн дээрх 6 төсөл арга хэмжээний хүрээнд нийт 4,968.5 сая төгрөгөөр 2,403 ширхэг тоног төхөөрөмж бий болсноос төрийн байгууллагын хэрэгцээнд 658.6 сая төгрөгийн 104 ширхэг тоног төхөөрөмж ашиглагдаж байна.

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ 3,350.1 сая төгрөгийн 2,173 ширхэг тоног төхөөрөмж, ХХААГ 959.9 сая төгрөгийн 126 ширхэг тоног төхөөрөмжийг ашиглуулах гэрээгээр иргэн аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн байна.

**БҮЛЭГ 2. Төлөвлөсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан боловч техникийн тодорхойлолтыг бодитой хийгээгүйгээс зах зээлийн үнээс хэт өндөр дүнтэй тоног төхөөрөмж худалдаж авчээ.**

2.1 Эрх шилжсэн төсөл арга хэмжээг ХАА-ны төлөвлөгөөнд тусган, НТШ-ын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

ТБОНӨХБАҮХАТХ-ий 44.4.<sup>7</sup>-т заасны дагуу Засаг дарга Орхон аймгийн ТЕЗ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, цахим системд нийтэлсэн байна.

Орхон аймгийн Засаг даргад ТЕЗ-ийн 5 шийдвэрээр 45,307.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 19,145.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 12 төсөл арга хэмжээний эрх шилжсэн байна.

### Эрх шилжсэн төсөл арга хэмжээний жагсаалт

Хүснэгт 8

/сая төгрөгөөр/

Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТЕЗ	Эрх шилжсэн шийдвэр
III.2.1.3	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн барилга /Орхон, Баян-Өндөр сум/	2,458.2	2,458.2	ЭЗХС	ЗГ-ын 2023.11.22 -ний өдрийн 409 дүгээр тогтоол
XIII.1.1.330	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/	2,916.3	1,458.2	БШУС	
III.2.3.1	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	783.0	783.0	ЭЗХС	ЗГХЭГД-ын 2024.01.30 -ны 11 дүгээр тушаал
V.1.4	Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/	2,789.3	199.3	ЗГХЭГД	
XIII.1.1.309	Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/	15,795.2	4,738.6	БШУС	Боловсролын сайдын

<sup>7</sup>Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ”

XIII.1.1.310	Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2А хороолол/	15,795.2	4,738.6	БШУС	2024.08.16 А/29
XVI.2.3.13	Орхон аймгийн Номын сангийн тоног төхөөрөмж	250.0	250.0	Соёлын сайд	Соёлын сайдын 2024.02.06 -ны А/30
XVIII.3.27	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/	820.0	820.0	ХХААХҮС	ХХААХҮС- ЫН 2024.01.11 А/14
XVIII.3.6	"Шинэ хөдөө - Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	500.0	ХХААХҮС	
XVIII.3.7	"Шинэ хөдөө-хүлэмж" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	500.0	ХХААХҮС	
XVIII.3.8	"Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500.0	500.0	ХХААХҮС	
XVIII.3.9	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	2,200.0	2,200.0	ХХААХҮС	
<b>Нийт</b>		<b>45,307.2</b>	<b>19,145.9</b>		

Орхон аймгийн засаг даргад эрх шилжсэн 12 төсөл арга хэмжээнээс 1 ТАХ нь он дамжин хэрэгжиж буй ТАХ байна.

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь тайлант онд эрх шилжсэн 11 ТАХ-ны худалдан авах ажиллагааг НТШ-ын аргаар зохион байгуулж, 2 ТАХ-г 7 багц, 4 багц болгон задалж, нийт 21 удаагийн тендер шалгаруулалтыг хууль журмын дагуу зохион байгуулжээ.

ХАА-ны газар нь 5 сайдын багцын 42,517.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 40,746.3 сая төгрөгөөр 20 гүйцэтгэгчийг сонгож, 1,771.6 сая төгрөгийн хэмнэлт үүсгэжээ.

Хүснэгт 9

ХАА зохион байгуулсан байдал

/сая.төгрөгөөр/

№	ТЕЗ	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Шалгарсан үнийн дүн	Тендерийн хэмнэлт
1	ЭЗХС	III.2.1.3	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн барилга /Орхон, Баян-Өндөр сум/	2,458.2	2,449.02	9.18
2	БС	XIII.1.1.330	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль/	2,916.3	2,872.53	43.77
3	БС	XIII.1.1.309	Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/	15,795.2	14,920.23	874.97
4	БС	XIII.1.1.310	Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2А хороолол/	15,795.2	15,297.45	497.75
5	ЭЗХС	III.2.3.1	Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн	783.0	65.78	136.67
6			Багц-1 Зөөврийн компьютер		39.40	
7			Багц-2 Контейнер		239.79	
			Багц -3 Хүлэмж			

8			паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	Багц-4 Оёдлын машин		84.15	
9				Багц-5 Суудлын автомашин		117.54	
10				Багц-6 Ачааны автомашин		77.77	
11				Багц-7 Илгээмж зөөврийн автомашин		21.90	
12	ХХААХҮС	XVIII.3.27	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/		820.0	720.94	99.06
13	ХХААХҮС	XVIII.3.9	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/		2,200.0	2,200.00	-
14	ХХААХҮС	XVIII.3.7	"Шинэ хөдөө-хүлэмж" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/		500.0	492.50	7.50
15	ХХААХҮС	XVIII.3.8	"Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/		500.0	467.41	32.59
16	ХХААХҮС	XVIII.3.9	"Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	Багц №1 Трактор худалдан авах		188.48	
17	ХХААХҮС			Багц №2 Лабораторийн тоног төхөөрөмж		72.82	
18	ХХААХҮС			Багц №3 Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний оношлуур	500.0	70.06	58.65
19	ХХААХҮС			Багц №4 Дотоодод үйлдвэрлэгдсэн Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний оношлуур		110.00	
20	СС	XVI.2.3.13	Орхон аймгийн Номын сангийн тоног төхөөрөмж		250.0	238.49	11.51
<b>Нийт дүн</b>					<b>42,517.9</b>	<b>40,746.3</b>	<b>1,771.6</b>

2.2. Тендерийн тодорхойлолт, тавигдах шаардлагыг батлахдаа худалдан авах барааны шинж чанар, материалын талаар тодорхой тусгаагүйгээс зах зээлийн үнээс хэт өндөр дүнтэй тоног төхөөрөмж худалдаж авсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх эрх шилжсэн 11 ТАХ-ний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулан батлуулж, тендерийг цахимаар зохион байгуулсан байна.

Захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолтод зарим тоног төхөөрөмжийн үнийг зах зээлийн үнээс хэт өндрөөр тусгасан байна. Тухайлбал:

- Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж 783.0 сая төгрөгийн төсөвт өртгийг 7 багц болгон задалснаас багц 5 буюу суудлын автомашины техникийн тодорхойлолтыг Соната-8 маркийн тээврийн хэрэгслийг 2016 оноос хойш үйлдвэрлэсэн байх, үнийн судалгааг 59.0 сая төгрөг гэж ирүүлсэн. Гүйцэтгэгч "Хөх тавилан" ХХК нийлүүлэхдээ 2016 онд үйлдвэрлэсэн Соната-8 маркийн тээврийн хэрэгслийг 58.8 сая төгрөгөөр 2 тээврийн хэрэгсэл нийлүүлсэн бол зах зээлийн бодит үнэ 30.0-45.0 сая төгрөг байна.

- Орхон аймгийн Номын сангийн тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтод



хүүхдийн өрөөний зөөлөн буйданг 100.0 мянган төгрөгийн үнэтэй, зөөлөн даавуун байдлаар тодорхойлсон боловч гүйцэтгэгч "Санаа мед трейд" ХХК тус бүрийг 700.0 мянган төгрөгөөр 5 ширхгийг нийлүүлсэн байна.

- "Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/, Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/ ТАХ-ний техникийн тодорхойлолтод зарим техник тоног төхөөрөмжийн үнийг зах зээлийн үнээс хэт өндөр үнээр тусгаж, баталсан байна.

Захиалагч техникийн тодорхойлолт батлахдаа зах зээлийн үнийн судалгааг бодитой хийж байх нь зүйтэй байна.

### 2.3 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа хууль журмын дагуу зохион байгуулагдсан байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тухай бүр үнэлгээний хороо байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулж батлуулсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ХАА-г зохион байгуулахдаа захиалагчийн шаардлагыг хангаагүй дараах тендерт оролцогчийг шалгаруулсан байна. Тухайлбал:

- *Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/- ТАХ-ний төсөвт өртөг 15,795.2 сая төгрөг бөгөөд ТАХ-ний тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн 18.1.<sup>8</sup>-т заасан байтал тендерт оролцогчийн сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын дүн 5,286.2 сая төгрөг байна.*

<sup>8</sup> Борлуулалтын орлогын хэмжээ: сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 оны борлуулалтын орлогын нийлбэр нь тухайн ажлын төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх

- *Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн барилга /Орхон, Баян-Өндөр сум/-ын тендерийн баримт бичгийн Өгөгдлийн хүснэгтийн 19.1-д “техникийн чадавх болон туршлагын мэдээлэлд ерөнхий инженер-1, мэргэжил барилгын инженер гэж заасан боловч оролцогчийн тендерийн баримт бичигт мэргэжлийн үнэмлэх нотлох баримтаар байхгүй байна.*

ХАА-ны газар нь эрх шилжсэн 12 ТАХ-ний 20 тендер шалгаруулалтаас дээрх 2 ТАХ-ээс бусад ТАХ-ний ХАА-г хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Эрх шилжсэн 3 ТАХ-ны үнэлгээний хороог 2024 оны 02 дугаар сард, 03 дугаар сард байгуулсан боловч тендерийг 2024 оны 08 сар, 10 сар, 12 дугаар сард зарлаж, гэрээ байгуулах эрхийг 2024 оны 10 дугаар сарын 10, 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр олгосон нь тухайн төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжих, ажлын гүйцэтгэл оройтсоноос хамаарч тухайн онд олгогдох санхүүжилтийг бүрэн авахгүй байх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Харин зохион байгуулсан 20 тендер шалгаруулалтаас 2 ТАХ-ны сонгон шалгаруулах явцад тендерт оролцогчоос 3 удаа 3 аж ахуйн нэгж Сангийн яаманд гомдол гаргаж, Сангийн яам тендерийг түдгэлзүүлсэн байна.

**БҮЛЭГ 3. Төсөл арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлж байгаа ч хөрөнгийн хэрэгцээ шаардлага оновчгүйгээс ашиглалт хангалтгүй, хяналтгүй байна.**

### 3.1 Төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгосон байна

Орхон аймгийн Засаг даргад эрх шилжсэн 5 сайдын багцаас 16,632.3 сая төгрөгийн санхүүжилт орсноос 2<sup>9</sup> ТАХ-нд гүйцэтгэл гараагүй тул санхүүжилт олгоогүй байна.

Гүйцэтгэлээр 10 ТАХ-ний 21 аж ахуйн нэгжид 15,327.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, зохиогчийн хяналтын зардалд 57.7 сая төгрөг, техник хяналтын зардалд 247.4 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Харин барьцаа хөрөнгийн дансанд хэрэгжиж дууссан 2 ТАХ-ны барьцаа 5% болох 509.8 сая төгрөг, ЭЗХС-аас эрх шилжсэн 1 ТАХ он дамжин хэрэгжихээр гэрээ сунгагдсан тул дансны үлдэгдэл 489.8 сая төгрөг нийт 999.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### Санхүүжилтийн мэдээлэл

Хүснэгт 12

/сая төгрөгөөр/

№	ТЕЗ	Эрх нээсэн дүн	Гүйцэтгэгчид олгосон	Зохиогчийн хяналтад олгосон	Барьцаа 5%	Техник хяналтын дансанд төвлөрүүлсэн	Барьцааны дансанд төвлөрүүлсэн
1	ЗГХЭГ	198.97	55.15	-	139.47	4.36	-
2	БШУС	10,212.83	9,570.79	48.01	370.31	181.26	-

<sup>9</sup> Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор, Ирээдүйн одод сургууль, Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2А хороолол

3	ХХААХ ҮС	4,322.20	4,322.20	-	-	-	-
4	СС	238.49	238.49	-	-	-	-
5	ЭЗХС	1,659.84	1,141.09	9.65	-	61.75	489.80
	<b>ДҮН</b>	<b>16,632.33</b>	<b>15,327.71</b>	<b>57.67</b>	<b>509.78</b>	<b>247.37</b>	<b>489.80</b>

Өмнөх онд ЗТХС-аас эрх шилжсэн хөрөнгө оруулалтын үлдэгдэл 486.7 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байснаас тайлант онд “Хот хоорондын болон аймаг хоорондын зорчигч тээврийн авто буудал /Орхон, Баян-Өндөр сум/”-ын ТАХ бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн бөгөөд үлдэгдэл ажлын гүйцэтгэл 237.9 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгож, 248.8 сая төгрөгийн барьцаа 5%-ийг тус дансанд үлдээсэн байна.

Эрх шилжсэн төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг ТЕЗ-д буцаан төвлөрүүлэхгүй, барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж, дараа оны гүйцэтгэлээр санхүүжилт олгож буй нь ТАХ-ний хэрэгжилт удаашрах, санхүүжилт зарцуулалтад тавих хяналтыг сулруулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 43.5.<sup>10</sup>-т, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.8.5<sup>11</sup> дах заалттай нийцэхгүй байна.

Мөн тайлант онд Орхон аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь Эдийн засаг, хөгжлийн сайдын ЭШХО-ын данснаас олгох 7.5 сая төгрөгийн зохиогчийн хяналтын зардлыг Боловсролын сайдын ЭШХО-ын данснаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 37.1.1<sup>12</sup>, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.8.3<sup>13</sup>-т заасныг зөрчсөн байна.

**3.2 ТАХ-ний гэрээг дүгнэж, ашиглагч талд хүлээлгэж өгдөг боловч гүйцэтгэгч байгууллагаас хамааралтай төсөл арга хэмжээ хугацаандаа дуусахгүй он дамжсаар байна.**

Төсвийн тухай хуулиар 2024 онд хэрэгжиж дуусах 20 ТАХ байгаагаас хугацаандаа бүрэн хэрэгжиж дууссан 14 ТАХ-ны 5 ТАХ барилга байгууламж, 9 ТАХ нь тоног төхөөрөмж, өмнөх оноос дамжин хэрэгжиж 2024 онд дууссан 1ТАХ нийт 15 ТАХ-г ашиглагч талд хүлээлгэн өгч гэрээг дүгнэсэн байна.

### **Төсөл арга хэмжээ хүлээлгэн өгсөн жагсаалт**

Хүснэгт 13

/сая төгрөгөөр/

<sup>10</sup> Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй

<sup>11</sup> Төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн зарцуулаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд бууруулж тайлагнана

<sup>12</sup> “төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих

<sup>13</sup> Аймаг, нийслэлийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж нь энэ журмын 2.8.2-т заасан цахим системээр дамжаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зохих журмын дагуу эрх нээснээс хойш ажлын 2 хоногийн дотор гүйцэтгэгч байгууллагад болон захиалагчийн холбогдох дансанд тус тус шилжүүлнэ

№	Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжиж дууссан эсэх	Гэрээ дүгнэсэн актын дугаар
1	III.2.3.1	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	Дууссан	УТ2401502587
2	IV.1.3.5	Онцгой байдлын тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	Дууссан	УТ2400900256
3	III.2.1.3	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн барилга /Орхон, Баян-Өндөр сум/	Дуусаагүй	-
4	IV.3.3.1	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	Дууссан	ХА/01-30
5	V.1.4	Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/	Дууссан	12/26/2023 36/2023
6	XIII.1.1.1	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/	Дууссан	18/22
7	XIII.1.1.201	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг/	Дууссан	УТ2101500443
8	XVII.1.30.2	Төв дулааны цэвэр усны шугам, ус дулаан дамжуулах төвийн барилга, гадна инженерийн шугам сүлжээний ажил /Орхон, Баян-Өндөр сум, Их залуу баг/	Дууссан	2022/485, 2023/186
9	XVI.2.3.13	Орхон аймгийн Номын сангийн тоног төхөөрөмж	Дууссан	УТ2403401602
10	XVII.1.9	Багийн явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэнбүст баг/	Дууссан	-
11	XVIII.3.27	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/	Дууссан	УТ2401900395
12	XVIII.3.6	"Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	Дууссан	УТ2401900401
13	XVIII.3.7	"Шинэ хөдөө-хүлэмж" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	Дууссан	УТ2401900399
14	XVIII.3.8	"Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	Дууссан	УТ2401900400
15	XVIII.3.9	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	Дууссан	УТ2401900396
16	XII.3.1.2	Хот хоорондын болон аймаг хоорондын зорчигч тээврийн авто буудал /Орхон, Баян-Өндөр сум/	Дууссан	УТ2115000442
17	XIII.1.1.4	Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/	Дуусаагүй	-
18	XIII.2.1.1	Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/	Дуусаагүй	-
19	XVII.1.30.1	Ф720 мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөлийн ажил /Орхон, Баян-Өндөр сум/	Дуусаагүй	-
20	XVII.1.30.3	Төв дулаан, цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ус дулаан дамжуулах төв барих ажил /Орхон, Баян-Өндөр сум, Цагаан чулуут, Наран баг/	Дуусаагүй	-
21	XVII.1.30.4	Эрх чөлөөний гудамжны уулзварын өргөтгөлийн инженер шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /Орхон, Баян-Өндөр сум, Уурхайчин баг/	Дуусаагүй	-


Тайлант онд хэрэгжиж дууссан 15 ТАХ-ний 9 ТАХ нь тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ бөгөөд бүгд нийлүүлэгдэж дууссан, гэрээ дүгнэсэн актаар баталгаажсан байна.

Барилга байгууламж барих, тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгч байгууллагууд гэрээг 1-5 удаа сунгасан байна.

Захиалагч, гүйцэтгэгчтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, худалдан авах гэрээнд “гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал энэ тухайгаа уг нөхцөл байдал үүссэнээс хойш 10 хоногийн дотор нөгөө талд мэдэгдэж гэрээг гүйцэтгэх хугацааг сунгана” гэж заасан байтал гэрээг сунгах гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийг хэрхэн үнэлж гэрээг сунгасан талаарх нотлох баримт хангалтгүй байна.

**Төлөвлөсөн хугацаанд дүүссэн барилга байгууламж:**

- 1. Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/:** 2,789.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Талст билэг” ХХК гүйцэтгэж, 2024 онд ашиглалтад бүрэн хүлээлгэн өгсөн. Гэрээг 36/2023 дугаар актаар дүгнэж, ашиглагч байгууллагаар Баян-Өндөр сумын ЗДТГ байна.




- 2. Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг/:** 7,406.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Хөх тавилан ХХК гүйцэтгэж 2024 оны 12 дугаар сард хүлээлгэн өгч, УТ2101500443 актаар гэрээг дүгнэсэн.



Ашиглалтад ороод удаагүй боловч спорт заалны дээд талд мөөгөнцөртсөн, урлаг заалны хананаас ус нэвчсэн, коридорын хананы доороос чийг цохиж будаг эмульс хуурсан, 00-ын өрөөний далд шугамууд бөглөрснийг ил болгосон, ашиглагч байгууламж сэтгэл ханамжгүй байгаа нь хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна.



**3. Хот хоорондын болон аймаг хоорондын зорчигч тээврийн авто буудал /Орхон, Баян-Өндөр сум/:** Шинжүү ХХК гүйцэтгэж, 2024 онд ашиглалтад өгч, гэрээг УТ211500442 актаар дүгнэсэн.



**4. Төв дулааны цэвэр усны шугам, ус дулаан дамжуулах төвийн барилга, гадна инженерийн шугам сүлжээний ажил /Орхон, Баян-Өндөр сум, Их залуу баг/:** “Эрин гүрэн” ХХК-гүйцэтгэж хүлээлгэж өгсөн боловч ашиглагч тал бүртгэл тайланд тусгаагүй, гүйцэтгэгч байгууллага баримт бичиг бүрдүүлж өгөөгүй шалтгаанаар одоог хүртэл бүртгэл тайланд тусгагдаагүй байна.



- 5. Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/:** Ажлын гүйцэтгэлийн барьцаа болох 20.7 сая төгрөг 2024 онд батлагдаж, гүйцэтгэгч байгууллагаар дээврийн ажлын засварыг гүйцэтгүүлсэн байна.

**Дуусаагүй барилга байгууламж:**

- 1. Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн барилга:** Тайлант онд бүрэн дуусган хүлээлгэж өгөхөөр санхүүжилт батлагдсан боловч ажлын гүйцэтгэл 90%-тай, санхүүжилтийн гүйцэтгэл 83%-тай, ашиглагч байгууллагын урсгал зардлыг шийдвэрлээгүйгээс хамаарч хойшлогдсон.




- 2. Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/:** Анхны төсөвт өртөг 798.6 сая төгрөг, Хан атрибут ХХК-тай БСШУСЯ/201801018 гэрээг байгуулж, ажлын гүйцэтгэл 68%-тай, гэрээний хугацаа 2022 онд дууссан. БЕГ-н 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 01/853 дугаарт албан бичгээр гэрээг цуцлах тухай мэдэгдлийг хүргүүлсэн. Барилгын хөгжлийн төвийн 2024 оны 09 дүгээр 19-ны өдрийн 1754/2024 дугаар магадлалын дүгнэлтээр хийгдээгүй ажлын тоо хэмжээг 876.0 сая төгрөгөөр тодорхойлсон байна.



**3. Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/:** Нийт төсөвт өртөг 10,557.7 сая төгрөг, “Нью сувагт констракшин” ХХК-тай УТ2001500173 дугаарт гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэл 72%-тай, санхүүжилтийн гүйцэтгэл 65%-тай ТЕЗ-ийн барьцаа дансанд үлдэгдэл санхүүжилт байршсан. 2025 оны 08 дугаар сард хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.



**4. Ф720 мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөлийн ажил /Орхон, Баян-Өндөр сум/:** Нийт төсөвт өртөг 4,321.2 сая төгрөг, Эрин гүрэн ХХК-тай 2022/382 гэрээ байгуулсан. Зураг төсөв бодитой хийгдээгүйгээс өргөлтийн насост шугамын хоолой холбогдоход 30-40м дутуу, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын төв шугамд холбоход аркаар давуулах зай талбай байхгүйгээс холбох боломжгүй болсон.



Эрдэнэтийн дулааны цахилгаан станцаас гарч буй шугамд холбогдоход дээр зурагт харуулсан аркаар хоолой гарах ёстой бол аркад илүү хоолой багтах зай байхгүй,

зураг төсөвт арк хийх төсөв суугдаагүйгээс төсөл арга хэмжээ бүрэн дуусах боломжгүй болсон.

- 5. Төв дулаан, цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ус дулаан дамжуулах төв барих ажил /Орхон, Баян-Өндөр сум, Цагаан чулуут, Наран баг/:** Эрин гүрэн ХХК-тай 4,329.5 сая төгрөгийн гэрээтэй ажлын гүйцэтгэл 80%-тай, гүйцэтгэгч байгууллага ажлыг оройтуулж эхэлснээс хамаарч хугацаандаа дуусаагүй.



- 6. Эрх чөлөөний гудамжны уулзварын өргөтгөлийн инженер шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /Орхон, Баян-Өндөр сум, Уурхайчин баг/:** Гүйцэтгэгчээр талст билэг ХХК сонгуультай холбоотой ажлыг хойшлуулж, 2025 оны 05 дугаар сараас эхлэхээр болсон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2025, 2026 онд дамжин хэрэгжих 9 ТАХ байгаагаас 4 ТАХ огт эхлээгүй, 3 ТАХ гүйцэтгэлийн үе шат явагдаж, 2 ТАХ ашиглалтад ороогүй нэмэлт төсөв шаардлагатайн улмаас зогссон байдалтай байна.

- 1. Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/:** Төсөвт өртөг 16,489.3 сая төгрөг, 2024 оны санхүүжих дүн 4,190.8 сая төгрөг, Уран хангай групп ХХК-тай БЗА-63/22 тоот гэрээтэй ажлын гүйцэтгэл 60%, 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс энэ оны ажил эхэлсэн, санхүүжилтийн гүйцэтгэл 50%-тай, 2025 оны 8 дугаар сард хүлээлгэж өгөх төлөвлөгөөтэй.



- 2. Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/:** Төсөвт өртөг 4,838.6 сая төгрөг, гүйцэтгэгчээр “Орчлон тулга” ХХК, ажлын гүйцэтгэл 25-30%-тай, санхүүжилт 1,400.0 сая төгрөг олгогдсон.



- 3. Ариутгах татуургын 3-р коллекторын төв шугам татах ажил /Орхон, Баян-Өндөр сум/:** Гүйцэтгэгч “Компорт импекс” ХХК, ажлын гүйцэтгэл 80%-тай энэ онд хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй.



- 4. Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/:** 3,944.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2020 онд эхэлж 2022 оноос хойш юу ч хийгдээгүй, Барилгын хөгжлийн төвийн магадлалын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 1865/2024 дүгнэлтээр хийгдээгүй ажлын төсвийг 5,003.8 сая төгрөг байхаар тооцсон.



- 5. Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/:** Төсөвт өртөг 3,953.6 сая төгрөг, 2019 онд “Жам” ХХК-тай улсын төсөвт 2,500.0 сая төгрөг баталснаар гэрээ байгуулж, 1,950.0 сая төгрөгийн санхүүжилт авсан. Ажлын гүйцэтгэл 55%-тай, 2022, 2023 онд төсөв батлаагүй, 2024 оны төсөвт 100.0 сая төгрөг батлагдсан боловч ажил хийгдээгүй, хадгалалт хамгаалалтгүйгээс цонх хагарч дахин ашиглах боломжгүй болсон. Дээврийн ажил хийгдээгүйн улмаас борооны ус орж, барилгын шал болон суурь хийцэд нөлөөлсөн.



**Царцсан барилга, байгууламж:**

- 1. Соёлын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Наран баг/:** 2019 онд эхэлсэн, түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр Наяд констракшнтай 1,000.0 сая төгрөгийн гэрээг байгуулж, хүлээлгэж өгөөгүйгээс цонх хагарч, дээвэр бүрэн засагдах шаардлага үүссэн. Орхон аймгийн Засаг даргаас 2024 оны 02 дугаар сарын 14-ны 02/334 дугаар албан бичгээр Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан.




- 2. Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум Баянцагаан баг/:** Гүйцэтгэгч “Ээлт-Өлгий” ХХК-тай 1,749.1 сая төгрөгийн гэрээ байгуулж одоог хүртэл дуусгаж хүлээлгэж өгөөгүй, Засаг дарга 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 01/2743 дугаар албан бичгээр Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж, 142/ШШ2024/01702 дугаарт эвлэрлийн шийдвэр гарч, гүйцэтгэгч байгууллага 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гүйцэтгэж, ашиглагч талд хүлээлгэж өгөхөөр эвлэрлийн гэрээ байгуулсан байна.



### 3.3 Тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж, хүлээн авсан гэх боловч бодит байдал дээр тулган баталгаажуулах боломжгүй байна.

Барилга байгууламжийн төсөл арга хэмжээг зураг төсвөөс өөрчлөх бүр зохиогч болон бусад байгууллагатай зөвшилцөн зөвшөөрөл авч ажилласан байна. Тухайлбал:




**Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг/ :** Зохиогчоос зөвшөөрөл авч спорт заалны шал хулдаасан байсныг агч модон шал болгож, зөрүү төсөв 140.0 сая төгрөгийг ОНХО-аас шийдвэрлэж, гүйцэтгэгч байгууллагатай 139.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 136.8 сая төгрөг олгосон.



**Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг/ :** Зохиогч болон бусад байгууллагаас зөвшөөрөл авч гадна фасад хөөсөнцөр байсныг төсөвт өртөгт өөрчлөлт оруулахгүйгээр металл фасад болгон гүйцэтгэсэн.



**Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн барилга :** Зохиогч болон бусад байгууллагаас зөвшөөрөл авч дотор хана 12-ын тоосго байсныг өөрчлөн сэндвич болгож, төсөвт өөрчлөлт оруулаагүй.



**Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/:** Газрын байршил өөрчлөгдсөнтэй холбоотой доороо граштай байсныг больж, зохиогч болон бусад байгууллага зөвшилцөн гадна тохижилтын ажилд төсвийг шилжүүлсэн.



**Хот хоорондын болон аймаг хоорондын зорчигч тээврийн авто буудал /Орхон, Баян-Өндөр сум:** Гадна замын тохижилт асфальт байсныг бетон болгож, барилгын узелийн өрөө урдаасаа ордог байсныг байршил өөрчилж ардаас болгосон. Гадна фасад тоосгон өрлөгтэй, шаварлагатай байсныг металл фасад болгон зөрүү 84.7 сая төгрөгийг магадлашгүй ажлын төсвөөр гүйцэтгэсэн

Засаг даргад эрх шилжсэн доорх 6 төсөл арга хэмжээний хүрээнд 3,131 ширхэг 5,207.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эрх шилжээгүй хөрөнгө оруулалтаас 53 ширхэг 499.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 3,184 ширхэг 5,706.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна.

Аудитын явцад 5,706.5 сая төгрөгийн 3,184 ширхэг тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолттой тулган баталгаажуулалт хийхэд 13 ширхэг 85.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж дутуу нийлүүлэгдэж, 1,653.9 сая төгрөгийн 954 ширхэг нь байгууллага ашиглаж байна.

Орхон аймгийн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/ төсөл арга хэмжээнээс 2 нэр төрлийн 3 ширхэг 84.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж бодитоор ирээгүй байхад хүлээн авсан акт үйлдэж, санхүүжилтийг бүрэн олгож, ашиглагч байгууллага санхүүгийн бүртгэл тайланд тусгасан байна.

Иймд Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмжийг нийлүүлсэн “Хөх тавилан” ХХК-иас 84.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн актыг Орхон аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга нарт хариуцуулан тогтоов.

Харин Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк, ХХААГ-аар дамжин иргэн аж ахуйн нэгжид ашиглагдаж буй 3,967.4 сая төгрөгийн 2,226 ширхэг тоног төхөөрөмжөөс 1,861.6 сая төгрөгийн 1,169 ширхэг тоног төхөөрөмж нь иргэн, аж ахуйн нэгжтэй

ашиглах гэрээ байгуулсан, 2,105.8 сая төгрөгийн 1,057 ширхэг нь огт гэрээгүй тараагдсан байх тул тулган баталгаажуулах боломжгүй байна.

Тухайлбал: Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/ төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн 720.9 сая төгрөгийн 40 ширхэг тоног төхөөрөмж ОНӨГ-аас Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-т аймгийн Засаг даргын 2024 оны А/543 захирамжаар шилжүүлсэн боловч бодитой оршин байхгүй, ашиглалтын гэрээгүй байна.


Мөн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/ төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн 2,035 ширхэг 2,200.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөс 1,081 ширхэг 2,357.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж гэрээгүй, УИХ-ын гишүүний бие төлөөлөгч авч явсан, Хөвсгөл Булган, Завхан аймагт тараагдсан зэрэг нь бүртгэлээр тавих хяналтыг алдагдуулж, тоног төхөөрөмж гэрээгээр ашиглаж буй этгээд зориулалтын дагуу үр дүнтэй ашиглаж буй эсэхэд үнэлэлт өгөх боломжгүй байна.

Иймд аймгийн Засаг дарга болон ОНӨГ-т бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, тоног төхөөрөмж ашиглаж буй этгээд зориулалтын дагуу үр дүнтэй ашиглаж буй эсэхэд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

Мөн Номын сангийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн "Санаа мед трейд" ХХК 3 нэр төрлийн 10 ширхэг 1.1 сая төгрөгийн тавилга эд хогшлыг дутуу нийлүүлсэн байсныг аудитын явцад ашиглагч талд бүрэн хүлээлгэн өгч Нийтийн номын сангийн 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 36 дугаар албан бичгээр хүлээн авсан тухай албан бичиг ирүүлсэн байна.

3.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээг бүртгэлд тусгасан боловч, ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүйгээс хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсаар байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжсэн 26,047.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 15 ТАХ-г улсын комиссын болон бараа материал хүлээн авсан актаар ашиглалтад хүлээн авсан байна.



Ашиглалтад хүлээн авсан 15 ТАХ-ны 27 хувь буюу 16,798.9 сая төгрөгийн 4 барилга, байгууламж, 60 хувь буюу 5,706.6 сая төгрөгийн 9 тоног төхөөрөмж, 7 хувь буюу 2,172.4 сая төгрөгийн 1 зам, талбайн тохижилт, 7 хувь буюу 1,369.0 сая төгрөгийн 1 инженерийн шугам сүлжээ тус тус эзэлж байна.

Тайлант онд хэрэгжиж дууссан 24,678.9 сая төгрөгийн 14 ТАХ-г төсвийн болон ОНӨААТҮГ-ын 14 байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалын дансанд холбогдох шийдвэрийн дагуу бүрэн бүртгэсэн байна.

Гэвч Төв дулааны цэвэр усны шугам, ус дулаан дамжуулах төвийн барилга, гадна инженерийн шугам сүлжээний ажил /Орхон, Баян-Өндөр сум, Их залуу баг/-ын 1,369.0 сая төгрөгийн ТАХ-г хүлээн авсан боловч бичиг баримтын бүрдэл дутуу шалтгаанаар бүртгэл тайланд бүртгээгүй байна. Тус төсөл, арга хэмжээний зураг төсөвт цахилгааны эх үүсвэрийг шийдэж өгөөгүйн улмаас цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй, үр дүн тодорхойгүй хөрөнгийг төлөвлөж, санхүүжүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн ч тухайн онд дуусаагүй 32,739.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 ТАХ-г Орон нутгийн өмчийн газрын дуусаагүй барилгын дансанд бүртгэсэн байна.

Тайлант онд эрх шилжсэн 5,207.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 7 ТАХ-г 16 байгууллагатай гэрээ байгуулан, 3,131 ширхэг тоног төхөөрөмж худалдан авсан байна. Дээрх тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалд дараах зөрчил илэрлээ.

- *Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/ 2,200.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй тоног төхөөрөмж худалдан авах гэрээнд ашиглагч талаар Баян-Өндөр сумын Засаг дарга оролцсон байхад “Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн парк” ОНӨААТҮГ хүлээн авч, бүртгэлдээ тусгасан нь тоног төхөөрөмж худалдан авах 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн УТ2401900396 дугаартай гэрээний 4.2<sup>14</sup>-т заасантай нийцэхгүй байна.*

Харин доорх 7 багц ТАХ-ээс аймгийн Засаг даргын захирамжаар 1,191.0 сая төгрөгийн 142 ширхэг тоног төхөөрөмжийг бусад байгууллагад шилжүүлсэн, 748.5 сая төгрөгийн 108 ширхэг тоног төхөөрөмж Эрдэнэт ШУТП ӨӨААТҮГ, ХХАА-т хадгалагдаж байгаа нь ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүйгээс хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсаар байна.

### **Бусад байгууллагад хүлээлгэн өгсөн жагсаалт**

Хүснэгт 14

/сая төгрөгөөр/

№	Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	Гэрээний үнийн дүн	Ашиглагч байгууллага	Шилжүүлэн авсан байгууллага
1	III.2.3.1-05	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	117.54	Эрдэнэт ШУТП ОНӨААТҮГ	Аймгийн ЗДТГ
2	III.2.3.1-06	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	77.77	Эрдэнэт ШУТП ОНӨААТҮГ	Жаргалант сумын ЗДТГ
3	III.2.3.1-07	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	21.90	Эрдэнэт ШУТП ОНӨААТҮГ	Мэдээлэл шуурхай

<sup>14</sup> Ашиглагч нь захиалагчаас тавьсан шаардлагын дагуу нийлүүлэгчээс ирүүлсэн бараанд шалгалт хийж, туршсаны дараа актаар хүлээн авч үндсэн хөрөнгийн бүртгэлд зохих журмын дагуу бүртгэн байгууллагынхаа санхүүгийн тайланд бүртгэнэ.

					удирдлагын төв
4	XVIII.3.27	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/	720.94	Орон нутгийн өмчийн газар	Эрдэнэт ШУТП ОНӨААТҮГ
5	XVIII.3.6-2	"Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	72.82	Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Орхон аймгийн Мал эмнэлгийн газар
6	XVIII.3.6-3	"Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	70.06	Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Орхон аймгийн Мал эмнэлгийн газар
7	XVIII.3.6-4	"Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	110.00	Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Орхон аймгийн Мал эмнэлгийн газар
<b>НИЙТ ДҮН</b>			<b>1,191.03</b>		

Аудитын явцад эрх шилжсэн 7, эрх шилжээгүй 2 ТАХ-ны хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж байгаа болон бодитой оршин байгаа эсэхэд тооллого хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Орхон аймгийн Нийтийн номын сангийн тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ-ны хүрээнд 238.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй, 53 нэр төрлийн, 728 ширхэг тоног төхөөрөмж хүлээн авснаас тооллогоор 2.2 сая төгрөгийн 6 нэр төрлийн, 8 ширхэг тавилга, эд хогшил дутагдсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5<sup>15</sup>-т, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1<sup>16</sup>-т, 20.2.6<sup>17</sup>-т заасантай нийцэхгүй байна.

#### Дүгнэлт:

- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Улсын хөгжлийн жилийн 2024 оны төлөвлөгөөтэй 80 хувь уялдаж байна.
- ✓ Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй 7,761.2 сая төгрөгийн 7 ТАХ-г байна.
- ✓ Орхон аймгийн 8-р сургуулийн өргөтгөлийн урсгал зардлыг тооцоолоогүйгээс 13.0 сая төгрөгийн өр төлбөр ашиглагч байгууллагад үүссэн байна.
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн ТАХ-д хувийн өмчид шилжих, ашиг олох зорилготой 4,309.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээ төлөвлөсөн байна.

<sup>15</sup> “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих

<sup>16</sup> Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.

<sup>17</sup> эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах.

- ✓ Эрх шилжсэн төсөл арга хэмжээг ХАА-ны төлөвлөгөөнд тусган, НТШ-ын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.
- ✓ Тендерийн тодорхойлолт, тавигдах шаардлагыг батлахдаа худалдан авах барааны шинж чанар, материалын талаар тодорхой тусгаагүйгээс зах зээлийн үнээс хэт өндөр дүнтэй тоног төхөөрөмж худалдаж авсан байна.
- ✓ Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа хууль журмын дагуу зохион байгуулагдсан байна.
- ✓ Төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгосон байна.
- ✓ ТАХ-ний гэрээг дүгнэж, ашиглагч талд хүлээлгэж өгдөг боловч гүйцэтгэгч байгууллагаас хамааралтай төсөл арга хэмжээ хугацаандаа дуусахгүй он дамжсаар байна.
- ✓ Тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж, хүлээн авсан гэх боловч бодит байдал дээр тулган баталгаажуулах боломжгүй байна.
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээг бүртгэлд тусгасан боловч, ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүйгээс хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсаар байна.

**Зөвлөмж:****Орон аймгийн Засаг даргад:**

- Эрх шилжсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын данс хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.
- Анхан шатны шүүхийн шийдвэр гарсан Соёлын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Наран баг/, Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум Баянцагаан баг/ ТАХ-г дуусгах талаар үр дүнтэй арга хэмжээ авах.

ТАЙЛАН ХЯНАСАН:

Дарга, Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

Р.Пүрэвлхагва

Б.Буян-Ундрах

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН БАГИЙН ГИШҮҮД

Ахлах аудитор

Аудитор

Аудитор

Т.Болормаа

Ц.Одгэрэл

А.Лхагвагэрэл

## Байгууллагын санал:

ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,  
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033  
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621  
Цахим шуудан: info@erdenet.mn

2025.04.18 № 01/1157  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Тайлангийн дүгнэлт зөвлөмжийг анхааралдаа авч цаашид хэрэгжилтийг ханган ажиллах болно.

Тус тайланд тусгагдсан нэмэлт төсөв шаардлагатай, баригдаж дуусаагүй барилга байгууламж болох "Сургуулийн барилга, 250 /Орхон, Баян-Өндөр, Говил баг/, Сургуулийн барилга, 250 /Орхон, Баян-Өндөр, Рашаант баг/" төсөл арга хэмжээний дүгнэлт, зөвлөмжийг Үндэсний аудитын газраар гаргуулан, дэмжлэг үзүүлэх талаар тайландаа нэмэлтээр тусгаж Сангийн яаманд хүргүүлж өгөхийг хүсье.

ЗАСАГ ДАРГА



Б.ЗОРИГТБАЯР

6125090565



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 211/А/1470338  
ГНАГ-2025/06-13-ШТА-ГА

Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орхон аймгийн Засаг даргад эрх шилжсэн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмжийг аудитын явцад тулган баталгаажуулахад 2 нэр төрлийн 3 ширхэг 84,114,500 (наян дөрвөн сая нэг зуун арван дөрвөн мянга таван зуун) төгрөгийн тоног төхөөрөмж бодитоор оршин байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна”, Төсвийн тухай хуулийн 4.1.36-т “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”; 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан


шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.7-д “төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмжөөс бодитоор оршин байхгүй 3 ширхэг тоног төхөөрөмжийн үнэ 84,114,500 (наян дөрвөн сая нэг зуун арван дөрөв таван зуу) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Орхон аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Орхон аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр, ЗДТГ-ын СТСХ-ийн дарга Л.Галсансайнхувьт, төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн Б.Энхжин нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРЭГЛЭХ  
АУДИТОР:  Т.БОЛОРМАА

АУДИТЫН  
МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АХЛАХ АУДИТОР:  Б.ПҮРЭВЛХАГВА

<sup>1</sup> Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-9826



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 228/А1470338  
ГНАГ-2025/06-13-ШТА-ГА

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орхон аймгийн Засаг даргад эрх шилжсэн 4 төсөл арга хэмжээнээс 1,073 ширхэг 2,355,697,378 (хоёр тэрбум гурван зуун тавин таван сая зургаан зуун ерэн долоон мянга гурван зуун далан найман) төгрөгийн тоног төхөөрөмжийг иргэн аж ахуйн нэгжид олгохдоо гэрээгээр эзэмшүүлээгүй, зориулалтын дагуу ашиглаж буй эсэхэд хяналт тавиагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27.1-т “Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно” 30.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6-т “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх; 13.3.2-т “хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан

зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ, Хүнс хөдөө аж ахуйн газраар дамжин иргэдэд гэрээгүй олгогдсон 1,073 ширхэг 2,355,697,378 (хоёр тэрбум гурван зуун тавин таван сая зургаан зуун ерэн долоон мянга гурван зуун далан найман) төгрөгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавиагүй зөрчлийг арилгах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Засаг дарга Б.Зоригбаяр, Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Эрдэнэчимэг, Шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ын захирал Г.Энхбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЭХ  
АУДИТОР:  Д. ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН  
МЕНЕЖЕР:  Б. БУЯН-УНДРАХ

АХЛАХ АУДИТОР:  Т. БОЛОРМАА

<sup>1</sup> Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-9826